



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 299

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 63,573,625.00 (жаран гурван сая таван зуун далан гурван мянга зургаан зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 2-ны өдрийн
200... дугаар тогтоолын хавсралт

"Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагаар худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэр лэсэн/ ашиглал тад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Краз кран, 47-65 УББ, тусгай, 7C42000048ERP	1987/1994	20500	61,252,038.00	61,252,038.00	0	0	4,000,000.00
2	Авто ачигч Модель, 42-14 УБ, тусгай	1994/2003	19450	2,321,587.00	2,321,587.00	0	0	800,000.00
	Нийт дүн			63,573,625.00 (жаран гурван сая таван зуун далан гурван мянга зургаан зуун хорин таван)	63,573,625.00 (жаран гурван сая таван зуун далан гурван мянга зургаан зуун хорин таван)	-	-	4,800,000.00 (дөрвөн сая найман зуун мянган)